

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ
ХЯНАЛТЫН СУУРЬ
КОНВЕНЦ




8 дугаар зүйлийг
хэрэгжүүлэх
Удирдамж



FCTC

WHO FRAMEWORK CONVENTION
ON TOBACCO CONTROL



ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

8 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамж:

“Тамхины утаанд өртөхөөс хамгаалах тухай”

Оролцогч талуудын Бага хурлын хоёрдугаар (шийдвэр дугаар FCTC/COP2(7))
хуралдаанаар баталсан.

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/m/item/protection-from-exposure-to-tobacco-smoke>

ДЭМБ-ЫН ТХСК-ИЙН 8 ДУГААР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

ТАМХИНЫ УТААНД ӨРТӨХӨӨС ХАМГААЛАХ ТУХАЙ

ЗОРИЛГО, ЗОРИЛТ БА ҮНДЭСЛЭЛ

Удирдамжийн зорилго

Энэхүү удирдамж нь ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенц (Суурь конвенц)-ийн 8 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь Оролцогч талуудад туслах зорилготой бөгөөд хүн амыг тамхины утаанд өртөхөөс хамгаалах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлсэн Оролцогч талуудын туршлага дээр үндэслэн бүтээгдсэн болно.

Удирдамж нь Оролцогч талуудын харилцан зөвшилцсөн нэр томъёо, зарчим болон 8 дугаар зүйлээр хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг агуулж байгаа болно. Түүнчлэн удирдамж нь тамхины утаанд өртөж хордох аюулаас хамгаалах үр дүнтэй арга хэмжээнүүдийг тодорхойлсон болно. Оролцогч талууд энэхүү удирдамжийг Конвенцийн дагуу хүлээсэн хууль ёсны үүргээ биелүүлэхэд төдийгүй нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаанд тэргүүн туршлага нэвтрүүлэхдээ ашиглах нь зүйтэй.

Удирдамжийн зорилт

Удирдамж нь харилцан хамаарал бүхий хоёр зорилттой. Үүнд: тамхины утаанд өртөхийн хор аюулын талаарх шинжлэх ухааны баримт, нотолгоо болон тамхигүй орчин бүрдүүлсэн улс орнуудын тэргүүн туршлагад тулгуурлан ДЭМБ-ын Суурь конвенцийн 8 дугаар зүйлээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хүн амын эрүүл мэндийг сайжруулахад нь Оролцогч талуудад туслахад эхний зорилт оршино. ДЭМБ-ын Суурь конвенцийн 8 дугаар зүйлд заасан олон нийтийг тамхины утаанд өртөж хордохоос үр дүнтэй хамгаалах хууль эрхзүйн үндсэн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлоход хоёр дахь зорилт оршиж байна.

Үндэслэл

Дараах нийтлэг зүйлүүдийг үндэслэн энэхүү удирдамжийг боловсруулсан болно.

- (а) 8 дугаар зүйлд заасан хүн амыг тамхины утаанаас хамгаалах үүрэг хариуцлага нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн болно. Тамхины утаагаар амьсгалах нь аюултай учраас хүн амыг тамхины утаанаас хамгаалах нь хүний амьд явах эрх, эрүүл амьдрах эрхийн талаар олон улсын хууль эрх зүйн олон баримт бичиг (Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Хэрэм үндсэн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах конвенц, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах конвенц, Эдийн засаг, нийгэм болон соёлын эрхийн тухай тунхаглал)-т хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд энэ талаар ДЭМБ-ын Суурь конвенцийн удиртгал хэсэгт албан ёсоор тусгагдаж, мөн олон улсын үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн билээ.

- (б) Хувь хүнийг тамхины утаанаас хамгаалах үүрэг хариуцлага нь хувь хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах төрийн үүрэгтэй нийцэж байна. Энэхүү үүрэг 3 нь хэсэг бүлэг хүнийг бус нийт хүн амыг хамарсан байна.
- (в) Дэлхийн тэргүүлэгч шинжлэх ухааны байгууллагууд дам 20 тамхины утаа нь хавдар үүсгэдэг болохыг тогтоосон. Тухайлбал ДЭМБ-ын Суурь конвенцид оролцогч зарим тал (ж.нь, Финлянд, Герман) дам тамхины утааг хавдар үүсгэгчийн ангилалд оруулан ажлын газар тамхины утаанд өртөхөөс урьдчилан сэргийлэх асуудлыг эрүүл мэндийн болон аюулгүй байдлын хууль тогтоомжууддаа тусгасан байна. Иймээс 8 дугаар зүйлд заасан шаардлагад нэмэлт болгож Оролцогч талууд тамхины утаанд өртөхийн хор аюулын талаар одоо мөрдөгдөж байгаа ажлын байрны болон хортой бодис/хавдар үүсгэгч бодисын талаарх хууль тогтоомжид тусган хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг.

ТАМХИНЫ УТААНД ӨРТӨХӨӨС ХАМГААЛАХ ТАЛААР БАРИМТЛАХ ЗАРЧИМ, НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Зарчим

ДЭМБ-ын Суурь конвенцийн 4 дүгээр зүйлд зааснаар нийт хүн амыг тамхины утаанаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд улс төрийн хүчин чармайлт чухал юм. Конвенцийн 8 дугаар зүйлийг хэрэгжүүлэхэд дараах хүлээн зөвшөөрөгдсөн зарчмууд удирдамж болж чадна.

Зарчим 1

ДЭМБ-ын Суурь конвенцийн 8 дугаар зүйлд заасанчлан тодорхой орон зай эсвэл орчинд тамхи татах, тамхины утааг бүрмөсөн үгүй болгож 100% тамхигүй орчин бий болгох нь тамхины утаанд өртөхөөс хамгаалах үр дүнтэй арга хэмжээ юм. Тамхины утаанд өртөхөд аюулгүй түвшин гэж байхгүй бөгөөд дам тамхидалтын эрүүл мэндэд хор хөнөөлгүй түвшин байдаг мэтээр ойлгох нь шинжлэх ухааны нотолгоотой сөргөлддөг тул үгүйсгэх ёстой ойлголт юм. Агааржуулалтын систем, агаарын шүүлтүүр, тамхи татах тусгай өрөө, тасалгаа (агааржуулалтын тусгай системтэй эсэхээс үл хамааран) гаргах зэрэг 100% тамхигүй орчин бүрдүүлэхээс бусад арга хэмжээ үр дүнгүй болох нь удаа дараа судалгаагаар батлагдсан бөгөөд инженерийн аливаа шийдэл нь тамхины утаанд өртөхөөс хамгаалж чадахгүй гэдгийг шинжлэх ухаан нотолж байна.

Зарчим 2

Бүх хүн тамхины утаанд өртөхөөс хамгаалагдсан байх ёстой. Бүх ажлын байр, олон нийтийн газар тамхигүй байх ёстой.

Зарчим 3

Тамхины утаанд өртөхөөс хүмүүсийг хамгаалахад хууль тогтоомж чухал. Сайн дураар тамхигүй орчин бий болгох бодлого үр дүнгүй болох нь олон дахин батлагдсан байна. Үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд хууль тогтоомж нь энгийн, тодорхой бөгөөд хэрэгжилтийг нь хангах боломжтой байвал зохино.

Зарчим 4

Тамхигүй орчин бий болгох хууль тогтоомжийг амжилттай хэрэгжүүлэхэд сайн төлөвлөлт болон хангалттай нөөц чухал.

Зарчим 5

Тамхигүй орчин бий болгох арга хэмжээнд дэмжлэг үзүүлэхэд иргэний нийгэм гол үүрэгтэй бөгөөд хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад идэвхтэй хамтран ажиллах нь зүйтэй.

Зарчим 6

Тамхигүй орчин бий болгох тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, түүний үр нөлөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийдэг байх. Үүнд ДЭМБ-ын Суурь конвенцийн 20.4 дүгээр зүйлд заасны дагуу тамхины үйлдвэрийн зүгээс гаргаж байгаа хууль зөрчсөн үйлдэл болон хариу арга хэмжээнд хяналт-шинжилгээ хийх асуудал нэгэн адил багтана.

Зарчим 7

Олон нийтийг тамхины утаанд өртөхөөс хамгаалах үйл ажиллагааг улам бүр бэхжүүлэх, шаардлагатай бол хууль тогтоомжийг шинээр болон шинэчлэн боловсруулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, шинжлэх ухааны шинэ баримт нотолгоо, хуримтлуулсан туршлага дээр тулгуурлан шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэргээр өргөжүүлэх хэрэгтэй.

Нэр томъёоны тодорхойлолт

Хууль тогтоомжийг боловсруулах үед нэр томъёоны тодорхойлолтод онцгой анхаарах нь чухал юм. Олон орны туршлага дээр үндэслэн зарим нэр томъёоны тодорхойлолтын талаарх зөвлөмжийг зөвлөмжийг дараах хэсэгт толилуулж байна. Эдгээр тодорхойлолтууд нь ДЭМБ-ын Суурь конвенцид байгаа тодорхойлолтуудад нэмэлт болж байгаа болно.

“Дам тамхины утаа” буюу “орчин дахь тамхины утаа”

ДЭМБ-ын Суурь конвенцийн 8 дугаар зүйлд тамхины утаанд өртөх хэлбэрийг тодорхойлоход нийтлэг хэрэглэдэг ижил утгатай хэд хэдэн нэр томъёо байдаг. Тухайлбал “дам тамхины утаа”, “орчин дахь тамхины утаа”, “бусад хүний татсан тамхины утаа” гэх мэт. “Идэвхгүй тамхидалт”, “тамхины утаанд санамсаргүй өртөх” зэрэг нэр томъёог хэрэглэхгүй байх нь зүйтэй. Учир нь, тамхи үйлдвэрлэгчид энэ тодорхойлолтыг гуйвуулан тамхины утаанд “сайн дураараа” өртөж байгаа мэтээр ашиглаж болдгийг Франц болон бусад улсын туршлага сануулж байна. “Дам тамхины утаа”, “орчин дахь тамхины утаа” зэрэг тодорхойлолтуудыг хэрэглэх нь зохимжтой бөгөөд энэхүү удирдамжид “дам тамхины утаа” гэдэг тодорхойлолтыг хэрэглэж байна.

Дам тамхины утаа гэдгийг “янжуур болон бусад тамхин бүтээгдэхүүний шатаж байгаа үзүүрээс буюу тамхичны амьсгалаар гарч байгаа утаа” гэж тодорхойлж болох юм.

“Утаагүй агаар” гэж 100% утаагүй агаарыг хэлнэ. Энэ тодорхойлолт нь тамхины утаа харагдахгүй, үнэртэхгүй, мэдрэгдэхгүй, хэмжигдэхгүй агаар гэсэн утгыг агуулж байгаа бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй болно.¹

“Тамхи татах”

Энэ нэр томъёог тамхийг уушгилж байгаа эсэхээс үл хамааран ассан тамхин бүтээгдэхүүнийг эзэмших буюу эрх мэдэлдээ байлгахыг хэлнэ гэж тодорхойлж болно.

“Олон нийтийн газар”

“Олон нийтийн газар” гэсэн нэр томъёог хууль тогтоомжид аль болох өргөн хүрээтэй тодорхойлох нь зүйтэй юм. Энэхүү тодорхойлолтод эзэмшлийн хэлбэр, нэвтрэхэд хязгаарлалт тавьдаг эсэхээс үл хамааран олон нийтэд нээлттэй буюу хүмүүс олноороо цугларч болох бүх газрыг хамруулсан байвал зохино.

“Дотоод” эсвэл “хаалттай” орчин

19.8 дугаар зүйл нь бүх ажлын байр болон олон нийтийн газрын “дотоод” орчныг тамхины утаанаас хамгаалахыг шаарддаг. “Дотоод” орчныг оновчтой тодорхойлох нь онцгой ач холбогдолтой тул улс орнуудад энэ ойлголтыг хэрхэн тодорхойлж байгааг тусгайд нь судлах нь зүйтэй юм. Тодорхойлолт нь аль болох ойлгомжтой, өргөн хүрээтэй байж, хамрагдах ёстой газруудыг аль болох орхигдуулахгүй байх шаардлагатай. “Дотоод” (эсвэл “хаалттай”) орчин гэж дээвэртэй, нэг буюу хэд хэдэн хана, талуудаар хүрээлэгдсэн орон зай юм (барилгын материал, орон зайг түр зуур буюу байнга ашиглахаас хамаарахгүй).

“Ажлын байр”

“Ажлын байр” гэдгийг “хүмүүс хөдөлмөр эрхлэх буюу ажил хийх үедээ ашиглаж байгаа аливаа орон байр” гэж өргөн утгаар ойлгож болно. Үүнд цалинтай байнгын ажлаас гадна цалин, урамшил өгдөг сайн дурын ажил мөн хамаарна. Түүнчлэн “ажлын байр” гэдэгт зөвхөн ажилладаг өрөө тасалгаа ороод зогсохгүй ажиллах явцад нийтээрээ ашиглаж болох хонгил, шат, лифт, үүдний өрөө, нийтээр амрах газар, цайны газар, бие засах газар, зоорь, саравч зэрэг барилгын гаднах хэсгүүд ч орно. Ажлын явцад хэрэглэж байгаа тээврийн хэрэгсэл ч мөн “ажлын байр” бөгөөд тусгайд нь авч үзэх ёстой юм.

Хорих газар, сэтгэцийн эмнэлэг, өндөр настны болон тахир дутуу хүмүүсийн асрамж, сувиллын газар зэрэг хувь хүний гэр орон мэт болсон ажлын байранд тусгай анхаарал хандуулбал зохино. Эдгээр нь мөн л бусад хүний ажлын байр болдог тул тамхины утаанаас хамгаалагдсан байх ёстой.

“Нийтийн тээврийн хэрэгсэл”

Нийтийн тээврийн хэрэгсэл гэж ашиг олох зорилгоор олон нийтийг тээвэрлэх зориулалттай аливаа тээврийн хэрэгслийг ойлгоно. Үүнд такси мөн хамаарна.

¹ Тамхины утаанд агуулагдах зарим бодис хэмжихэд хэцүү, маш бага хэмжээгээр агаарт байж болзошгүй юм. Тамхи үйлдвэрлэгчид, олон нийтийн үйлчилгээний байгууллагууд энэ тодорхойлолтын хязгаарлагдмал талыг ашиглах оролдлого хийж болзошгүйг анхааралдаа авах хэрэгтэй.

ҮР ДҮНТЭЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

8 дугаар зүйл нь (1) “хаалттай ажлын байр”, (2) “хаалттай Олон нийтийн газар”, (3) “нийтийн тээврийн хэрэгсэл” болон (4) “олон нийтийн бусад газар”-т хүмүүсийг тамхины утаанаас хамгаалах үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэхийг шаардаж байна.

Хаалттай олон нийтийн газар, хаалттай ажлын байр, нийтийн тээврийн хэрэгсэл болон бусад (задгай эсвэл хагас хаалттай) бүх олон нийтийн газарт дам тамхины утаанд өртөхөөс олон нийтийг хамгаалах үүргийг Оролцогч талууд хүлээнэ. Ингэхдээ эрүүл мэндийн болон хууль зүйн үндэслэлээр аль нэг газрыг орхигдуулж болохгүй бөгөөд хэрэв бусад үндэслэлээр зарим газрыг энэхүү зохицуулалтаас чөлөөлөхөөр бол үүнийг маш бага байлгах ёстой. Хэрэв Оролцогч тал олон нийтийг дам тамхины утаанд өртөхөөс бүрэн хамгаалах арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлж чадахгүй бол 8 дугаар зүйлд заасны дагуу аль болох богино хугацаанд орхигдуулсан газруудыг хамруулан хүн амыг дам тамхины утаанд өртөхөөс бүрэн хамгаалах арга хэмжээг авах үүрэгтэй. Оролцогч талууд ДЭМБ-ын Суурь конвенцийг хүчин төгөлдөр хэрэгжүүлж эхэлснээс хойш 5 жилийн дотор хүн амыг дам тамхины утаанд өртөхөөс бүрэн хамгаалсан байхын төлөө чармайн ажиллах ёстой.

Дам тамхины утааны аюулгүй түвшин гэж байхгүй бөгөөд Оролцогч талуудын бага хурлаас сайшаасан FCTC/COP1(15) шийдвэрт тусгагдсанаар агааржуулалт, агаарын солилцоо, тамхи татах тусгай байр гаргах зэрэг инженерийн арга хэмжээ нь тамхины утаанд өртөхөөс хамгаалж чадахгүй.

Бүх төрлийн ажлын байрны дотоод орчин буюу хаалттай ажлын байр, ажлын хэрэгцээний тээврийн хэрэгсэл (жишээ нь, такси, түргэний тэрэг, ачааны тээврийн хэрэгсэл) тамхины утаанд өртөхөөс хамгаалагдсан байх ёстой.

Конвенц нь зөвхөн бүх “хаалттай” олон нийтийн газар төдийгүй “бусад” “шаардлагатай” (задгай болон хагас хаалттай) олон нийтийн газар тамхины утаанд өртөхөөс хамгаалах үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхийг шаарддаг. Боломжтой бол задгай болон хагас хаалттай газарт дам тамхины утааны эрүүл мэндэд учруулах хор хөнөөлийг судалж, хор хөнөөлтэй болох нь тогтоогдмогц үр дүнтэй хамгаалах арга хэмжээг авч баталгаажуулахын төлөө ажиллах хэрэгтэй.

ХҮН АМД МЭДЭЭЛЭХ, ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ, ТЭДНИЙГ ТАТАН ОРОЛЦУУЛАХ ЗАМААР ДЭМЖЛЭГ АВАХ, СААДГҮЙ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Дам тамхины утаанд өртөх эрсдэлийн талаар мэдээлэл, сурталчилгааны байнгын кампанит арга хэмжээг зохион байгуулж олон нийт, тэдний дундах нөлөө бүхий хэсгийн мэдлэгийг дээшлүүлэх нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд олон нийтийн дэмжлэгийг авахад чухал үүрэгтэй юм. Үүнд үйлдвэрийн газар, ресторан болон үйлчилгээний байгууллагуудын холбоо, ажил олгогчид, мэргэжлийн нийгэмлэг, холбоод, хэвлэл мэдээлэл, эрүүл мэндийн мэргэжилтнүүд, хүүхэд, байгууллага, залуучуудын боловсролын болон шашны байгууллага, судлаачид болон нийт хүн амыг хамруулах нь зүйтэй. Мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээний дотор тогтоомжийг боловсруулах явцад гол сонирхогч талуудтай зөвлөлдөх нь чухал байр суурь эзэлдэг.

Олон нийтэд өгөх мэдээлэл нь дам тамхины утаанд өртөхийн хор хөнөөл, дотоод орчныг утаагүй байлгах нь дам тамхины утаанд өртөхөөс бүрэн

хамгаалах шинжлэх ухааны үндэслэлтэй цорын ганц арга зам бөгөөд бүх ажиллагсдын эрх хууль тогтоомжоор хамгаалагдсан байх ёстой зарчмыг таниулахад чиглэгдэнэ. Түүнчлэн эрүүл мэнд болон эдийн засгийн зорилтууд хоорондоо зөрчилдөхгүй, харин ч тамхигүй орчин аль алинд нь ашигтай болохыг судалгаа харуулж байна. Олон нийтийн боловсролд зориулсан кампанит ажлууд нь айл өрх зэрэг хууль тогтоомж хэрэгжихэд хүндрэлтэй газруудад чиглэгдэж байвал зохино.

Сонирхогч талуудтай өргөн хүрээтэй зөвлөлдөх нь олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, тэднийг дайчлах болон батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг авч хамтран ажиллахад нэн чухал юм. Хууль тогтоомж нэгэнт батлагдвал түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгааны кампанит ажил явуулах, бизнес эрхлэгчид болон байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагад хуулийн тухай мэдээлэл хүргэж үзүүлэн, тэмдэг байрлуулахад шаардлагатай хөрөнгө, нөөцийг гаргах зэрэг тэдний үүрэг хариуцлагыг ойлгуулах нь зүйтэй юм. Эдгээр арга хэмжээ нь хууль тогтоомжийг чанд сахиж, хэрэгжилтийг сайжруулах магадлалыг нэмэгдүүлнэ. Тамхи татдаггүй хүмүүсийг эрх мэдэлжүүлсэн, хууль тогтоомжийг сахин биелүүлж байгаад нь тамхи татдаг хүмүүст талархсан мэдээлэл нь хуулийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд тус дөхөм үзүүлнэ.

ХЭРЭГЖИЛТ

Хэрэгжүүлэх үүрэг

Хүчин төгөлдөр хууль тогтоомж нь холбогдох аж ахуйн нэгж, тамхичдад хууль сахиулах үүрэг хүлээлгэж, зөрчил гаргасан тохиолдолд аж ахуйн нэгж, магадгүй тамхичдад арга хэмжээ авах асуудлыг зохицуулах шаардлагатай. Хуулийн хэрэгжилтийг хянах үйл ажиллагаа нь аж ахуйн нэгжүүдэд төвлөрөх ёстой. Хууль тогтоомжоор аж ахуйн нэгжийн эзэн, менежер буюу байр хариуцаж байгаа хүнд үүрэг хариуцлага ногдуулж, авч хэрэгжүүлэх ёстой арга хэмжээг тодорхой зааж өгөх ёстой. Авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнд дараах зүйл багтана. Үүнд:

- (а) байрны орох хэсэг болон бусад холбогдох хэсэгт тамхи татахыг хориглосон тэмдэг байрлуулах тэмдгийн хэмжээ, агуулгыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад төрийн байгууллага тогтоох ёстой бөгөөд тэмдэг дээр зөрчил илэрсэн тохиолдолд мэдээлэх утасны дугаар, холбогдох бусад мэдээлэл болон тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдах албан тушаалтны нэрийг заасан байвал зохино;
- (б) байрнаас тамхины үнсний бүх савыг зайлуулах;
- (в) дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавих;
- (г) байранд тамхи татуулахгүй байхад чиглэсэн хэрэгжих боломжтой өвөрмөц шаталсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх - тухайлбал, тамхи татахгүй байхыг хүсэх, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, тухайн хүнийг байрнаас гарахыг хүсэх, хууль, хяналтын байгууллагад хандах зэрэг болно.

Шийтгэл ногдуулах

Хууль, тогтоомж нь зөрчил илэрсэн тохиолдолд ногдуулах шийтгэл эсвэл торгуулийн хэмжээг тодорхой заасан байх шаардлагатай. Торгуулийн хэмжээг тогтооход тухайн улс орны туршлага, зан заншлыг харгалзан үзэх хэрэгтэй бөгөөд шийдвэр гаргахдаа хэд хэдэн зарчмыг баримтлах ёстой. Хамгийн гол нь торгуулийн хэмжээг тогтоохдоо цаашид зөрчил гаргуулахгүй байх, гаргасан зөрчлөө тоохгүй, ердийн асуудал мэтээр хүлээж авахаас зайлсхийж хангалттай ихээр тогтооно. Хууль зөрчсөний шийтгэлийг хувь хүнд ногдуулахаас илүү аж ахуйн нэгжүүдэд ногдуулахад анхаарах нь зүйтэй. Давтан зөрчил гаргасан бол торгуулийн хэмжээг нэмэгдүүлэх ёстой бөгөөд үүнийг бусад ноцтой эрх зүйн зөрчлийн нэгэн адил авч үзэх ёстой.

Хууль тогтоомжид мөнгөн торгуулиас гадна үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг захиргааны шийтгэл ногдуулах талаар тусгасан байж болно. Ийм “эцсийн шатны шийтгэл”-ийг ховор хэрэглэдэг боловч аливаа аж ахуйн үйл ажиллагаанд хууль тогтоомж давтан зөрчигдөхөөс сэргийлж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой байдаг.

Тухайн улс орны соёл, хууль эрхзүйн тогтолцоог харгалзан зөрчил илэрсэн тохиолдолд эрүүгийн шийтгэл ногдуулах талаар авч үзэж болох юм.

Хэрэгжилтийг хангах дэд бүтэц

Хууль тогтоомжид түүний хэрэгжилтийг хариуцах нэг буюу хэд хэдэн байгууллагыг тодорхойлсон байх ёстой бөгөөд хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх болон хууль тогтоомж зөрчигчдэд ял, шийтгэл ногдуулах тогтолцооны аль алийг нь тодорхойлсон байх ёстой.

Хяналт-шинжилгээ нь аж ахуйн үйл ажиллагаанд хуулийг хэрхэн мөрдөж байгаа талаар хийх хяналт шалгалтын үйл явцыг багтаасан байвал зохино. Тамхигүй орчин бүрдүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоог шинээр бий болгох шаардлагагүй байдаг. Түүний оронд аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байранд хяналт тавьдаг бэлэн механизмыг ашиглан хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийж болох юм. Ихэнх улс оронд тамхины хяналтын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг аж ахуйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох хяналт, эрүүл мэндийн болон эрүүл ахуйн хяналт, ажлын байрны эрүүл, аюулгүй байдалд тавих хяналт, галын аюулгүй байдлын хяналт болон бусад төстэй хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлж болох юм. Ингэхдээ мэдээллийн хэд хэдэн эх үүсвэрийг ашиглах нь ач холбогдолтой байдаг.

Боломж байвал орон нутгийн хяналтын байцаагч, хуулийн хэрэгжилтийг хариуцах байгууллагуудыг оролцуулахыг зөвлөдөг. Энэ нь Энэ нь нэгэнт тогтсон хяналтын тогтолцоог бэхжүүлэхийн зэрэгцээ хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулдаг. Энэхүү аргыг үндэсний хэмжээнд нэвтрүүлэхэд үндэсний зохицуулалтын механизмтай болох шаардлагатай.

Хэрэглэж байгаа аргаас үл хамааран хяналт-шинжилгээ нь хууль, журмын хэрэгжилтийг хангах тодорхой төлөвлөгөөтэй байх ба төлөвлөгөөнд байцаагч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх сургалтын арга хэмжээ тусгагдсан байх ёстой. Хяналт-шинжилгээг үр дүнтэй болгохын тулд байнгын хяналт шалгалтыг төлөвлөгөөт бус, гэнэтийн шалгалт болон гомдлын мөрөөр явуулах үзлэг, шалгалттай хамтатган хийж болно. Ихэнх зөрчил санамсаргүй гардаг тул хууль мөрдөгдөх эхэн үед ийм үзлэг шалгалт явуулах нь сургамжтай байж болох юм.

Хэрэв одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжоор байцаагч нарт хууль тогтоомжид заасан газарт нэвтэрч орох, дээж авах, баримт нотолгоо цуглуулах эрх олгогдоогүй бол тэдгээр эрхийг хууль тогтоомжоор баталгаажуулж өгөх ёстой. Үүний нэгэн адил аж ахуйн нэгжүүдийн зүгээс байцаагч нарын үйл ажиллагаанд ямар нэг саад учруулахыг хууль тогтоомжоор хориглох ёстой.

Үр дүнтэй хяналт-шинжилгээний зардал нь тийм ч өндөр биш юм. Үүнд заавал олон байцаагч ажиллуулах шаардлагагүй бөгөөд байгаа хөтөлбөр, хүний нөөцийг түшиглэн явуулах боломжтой. Туршлагаас харахад утаагүй орчны хууль тогтоомж нь өөрөө аяндаа хэрэгждэг (ихэвчлэн олон нийтийн оролцоотойгоор хэрэгждэг). Хэрэв хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, бизнес эрхлэгчид болон олон нийтийн боловсролыг дээшлүүлэхэд онцгой анхаарч ажиллавал шүүхийн журмаар шийдвэрлэх хэрэг цөөн гардаг.

Энэхүү үйл ажиллагаа өртөг зардал багатай ч бизнес эрхлэгчдэд боловсрол олгох, байцаагч нарыг сургах, Хяналт шалгалтын ажлыг зохицуулах мөн ажлын бус цагаар хяналт шалгалт хийсэн тохиолдолд урамшуулал олгох + зэрэгт тодорхой нөөц шаардагддаг. Иймд шаардлагатай санхүүжилтийн механизмыг тодорхой болгох хэрэгтэй. Хяналт-шинжилгээний үр дүнтэй хөтөлбөрүүд нь татварын орлогын тодорхой хэсэг, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн төлбөр болон хууль зөрчигчдөд ногдуулсан торгууль зэрэг санхүүгийн эх үүсвэрийг ашигладаг.

Хэрэгжилтийг хангах стратеги

Хэрэгжилтийг хангах стратегийн арга нь хууль тогтоомжийг сахин биелүүлэх явдлыг нэмэгдүүлж, хэрэгжилтийг хялбаршуулан хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг хэмнэж чадна.

Хууль тогтоомж хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлмэгц түүний хэрэгжилтийг хангах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх болон хууль тогтоомж цаашид нь хяналт-шинжилгээ амжилттай хэрэгжихэд шийдвэрлэх ач холбогдолтой юм. Ихэнх улс оронд хууль хэрэгжих эхэн үед хууль зөрчигчдөд шийтгэл ногдуулалгүй анхааруулах арга хэмжээ авдаг байна. Энэ арга нь хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг хариуцлагынх нь талаар бизнес эрхлэгчдийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн идэвхтэй кампанит ажилтай уялдах ёстой бөгөөд бизнес эрхлэгчид ч мөн анхааруулгын эхэн үеийн дараагаар илүү хатуу чанд хэрэгжилтийн үетэй тулгарна гэдгийг ойлгох ёстой.

Хууль идэвхтэй хэрэгжиж эхэлсэн үед ихэнх улс оронд хэрэгжилтийг хангах хатуу арга хэмжээ хэрэгжүүлэхийг зөвлөмж болгодог. Хууль, тогтоомжийг илэрхий зөрчсөн олны сайн танил этгээдийг илрүүлэх, тууштай, хурдан арга хэмжээ авах, эдгээр арга хэмжээний талаар олон нийтэд зарлах зэргээр эрх бүхий байгууллагууд хуулийн хэрэгжилтэд шийдэмгий, хатуу хандаж байгаагаа харуулж чадна. Энэ нь хууль цаашид ямар нэг шахалт шаардлагагүйгээр хэрэгжих явдлыг сайжруулж цаашдын хяналт-шинжилгээ болон хэрэгжилтэд шаардагдах нөөцийг хэмнэдэг.

Утаагүй орчны хууль тогтоомж нь өөрөө аяндаа хурдан хэрэгждэг хэдий ч ямар нэг ил тод зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллагууд шийдэмгий арга хэмжээ авахад бэлэн байх шаардлагатай. Хууль тогтоомж анх мөрдөгдөж Бэхлэх үед ганц нэг зөрчигч олон нийтийн өмнө эсэргүүцлээ илэрхийлдэг. Ийм үед нь хуулийн хэрэгжилтийг хангах талаар шийдэмгий алхам хийснээр дүрэм журам сахиулах үндсийг бий болгож ирээдүйд зарцуулах хүч

хөдөлмөрийг багасгадаг бол шийдэмгий бус байдал нь зөрчлийг богино хугацаанд түгээмэл болгоход хүргэдэг байна.

Олон нийтийг дайчлах, оролцуулах

Олон нийтийн оролцоог нэмэгдүүлснээр хяналт-шинжилгээ болон хэрэгжилт үр дүнтэй болно. Олон нийтийн дэмжлэгийг авч, тэдний зүгээс хуулийн хэрэгжилтийг хянах, хууль зөрчсөн тохиолдлыг мэдээлэх явдлыг урамшуулж байх нь хэрэгжүүлэгч байгууллагуудын хүндээ хүрч ажиллах боломжийг нэмэгдүүлж, хууль сахиулахад зарцуулах нөөцийг хэмнэнэ. Олон нийтийн зүгээс гарч байгаа санал гомдол нь хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах анхдагч арга хэрэгсэл болдог. Тийм ч учраас утаагүй орчны талаарх хууль тогтоомжид иргэн бүр гомдол гаргаж болно гэдгийг онцлон тусгах ёстой бөгөөд тамхины утаанд өртөж хордохоос сэргийлэх арга хэмжээг хувь хүн, төрийн бус байгууллага санаачлан зохицуулах эрхийг баталгаажуулсан байх нь чухал. Зөрчлийн талаар олон нийтийн зүгээс мэдээлэх боломж олгох үүднээс үнэ төлбөргүй утас ажиллуулах эсвэл үүнтэй төстэй тогтолцоо бий болгох нь чухал юм.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ БА ҮНЭЛГЭЭ

Тамхины утаанд өртөж хордохоос сэргийлэх арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нь хэд хэдэн шалтгааны улмаас чухал юм. Тухайлбал:

- (а) хуулийн зохицуулалтыг чангатгах, хүрээг өргөтгөхийн тулд улс төрийн болон олон нийтийн дэмжлэгийг нэмэгдүүлэх;
- (б) бусад улс орны хүчин чармайлтад дэмжлэг үзүүлэх зорилгоор эерэг жишээнүүдийг баримтжуулах;
- (в) арга хэмжээний хэрэгжилтийг тасалдуулах гэсэн тамхи үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг илрүүлэн олон нийтэд мэдээлэх.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын цар хүрээ, бэрхшээлтэй тал нь хуулийн байгууллагуудын туршлага болон нөөцөөс хамааран янз бүр байдаг. Гэхдээ авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн, ялангуяа ажлын байр, олон нийтийн газарт дам тамхины утаанд өртөх явдал хэр зэрэг байгааг харуулсан гол үзүүлэлтийг үнэлэх нь чухал юм. Үүнд өртөг зардал багатай, тухайлбал ажлын байрны тогтмол хяналт шалгалтын тогтолцоог ашиглан мэдээлэл цуглуулах аргыг ашиглаж болно.

Анхааралдаа авбал зохих үйл явцын болон үр дүнгийн үндсэн найман үзүүлэлт байдаг.² Үүнд:

Үйл явц

- (а) нийт хүн ам болон тодорхой бүлэг хүмүүсийн, тухайлбал бааранд ажиллагсдын тамхины утаагүй орчин бүрдүүлэх бодлогын талаарх мэдлэг, хандлага болон дэмжлэг;
- (б) тамхины утаагүй орчин бүрдүүлэх бодлогын хэрэгжилт болон түүнийг сахиж байгаа байдал;

² Дам тамхины утаанд өртөж хордохоос хамгаалах тухай ДЭМБ-ын бодлогын зөвлөмжийн эмхэтгэл (Женев хот, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, 2007 он) нь эдгээр үзүүлэлтүүдийг ашиглан хийсэн хяналт-шинжилгээний талаар лавлагаа болно.

Үр дүн

- (в) ажлын байр болон олон нийтийн газар ажиллагсад дам тамхины утаанд өртөх явдал буурах;
- (г) ажлын байр (ялангуяа ресторан) болон олон нийтийн газрын агаарт байх тамхины утааны хэмжээ багасах;
- (д) дам тамхидалтаас үүдэлтэй өвчлөл болон нас баралт буурах;
- (е) гэр, орон сууцандаа дам тамхины утаанд өртөх явдал буурах;
- (ё) тамхины хэрэглээний тархалт ба тамхины хэрэглээтэй холбоотой зан үйлийн өөрчлөлт;
- (ж) эдийн засгийн үр нөлөө.

-oOo-